

Олон Улс Судлал №2, 2014 он: хуудас 93-104.

Зөвлөлт-Хятадын зөрчлийн оргил үе “1969 он”

Д.Баярхүү*

Энд бичигдсэн түүхэн сэдэв эдүгээ нууц биш болсон. Түүх түүхээрээ үлдэг, тэр түүхийг хойч үе маань мэдэг, сонирхог гэдэг үүднээс бичигдсэнийг ойлгох биз ээ. Үнэхээр хоёр их хөрш маань нийгмийн байгуулал нь нэг (социализм), зорилго нь нэг (коммунизм) байсан хэрнээ хил дээрээ зэвсэг хангинуулж, бүр байлдах дээрээ яагаад тулсан юм бэ гэдгийг зөвлөлтийн ба хятадын тухайн үеийн эх сурвалжид тулгуурлан олон тайлбаргүй дор буулгав. Харин гуравдугаар гарчиг нь зохиогчийн нэмэлт тайлбар болно.

Нэг. Хятад эх сурвалж ингэж өгүүллээ (Зөвлөлтийн жанжлалын эсрэг тэмцсэн нь)

Орчин үеийн хятадыг судлах хүрээлэнгээс хянаж туурвисан “БНХАУ-ын түүх” номыг 2012 онд “Жэньминь”, “Дандай Жунго” хэвлэлийн газруудаас Бээжинд 3 ботиор хэвлэн гаргажээ. Номын гутгаар ботид 1966-1976 оны түүхийг өгүүлсэн байх бөгөөд номын 7-р бүлгийн 2-р дэд бүлэгт гарчигт өгүүлсэн түүх “Хятадын эсрэг СССР-ийн жанжлалын цэргийн аюул” дэд гарчгаар бичигдсэнийг товчлон буулгаж толилууля.

* Д.Баярхүү ШУА-ийн ОУСХ-гийн “Олон улсын улс төрийн бодлого судлалын профессор”, Дипломат албаны Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин.

Жэньбаодао (Даманы арал) хавийн хориглон хамгаалалт, сөрөг давшилт ба бүх улс орон даяараа байлдааны бэлэн байдалд шилжсэн их давалгаа

Хятад-Зөвлөлтийн харилцаа муудсаны дараа Зөвлөлт-Хятадын хил дээр хилийн зөрчил будлианыг СССР-ийн зүгээс тасралтгүй өдөөв. 1964 оны 10 дугаар сараас 1969 оны 3 дугаар сар хүртэл зөвлөлтийн талаас өдүүлсэн хилийн зөрчил 4189-д хүрч, энэ нь 1960-1964 онд гарч байсан хилийн зөрчлөөс 2.5 дахин их болж өсчээ. Хятад-Зөвлөлтийн хилийн маргаан шатлан өргөжих тусам Жэньбаодао хавийн район мөргөлдөөний гол цэг боллоо. Жэньбаодао арал бол Хэйлунзян мужийн Хулинь уездын нутаг дэвсгэрт орших, Усури мөрний хагалбараар хилийн шугам дайрч өнгөрдөг, нэг хавтгай дөрвөлжин километр хүрэхтэй үгүйтэй жижиг газар, түүхийнхээ туршид Хятадын нутаг дэвсгэр гэгдэж ирсэн.

Хоёр орны харилцаа муудмагц СССР нь Жэньбаодао арлын эсрэг цэргийн өдөөн хатгалга үйлдэх болсон тул манай улсын бүрэн эрхт байдал, нэр төрийг хамгаалах, хил орчмын районы аюулгүй байдлыг хангах үүднээс Цэргийн төв зөвлөлөөс 1968.01.24-нд Бээжингийн цэргийн тойрог, Шэньяны цэргийн тойрог руу цахилгаан утас илгээж, Хятад-Зөвлөлтийн хилийн дорнод хэсгийг хамгаалах ажлыг эрчимжүүлэх үүрэг өгсөн болно. Үүнд өдөөн хатгалгыг хатуу няцаах, гэхдээ түрүүлж байлдахгүй, ухаалаг байж, арвилан хэмнэж батлан хамгаалалтын тодорхой арга хэмжээ авахыг хилийн цэргээсээ шаарджээ. 1969.01.25-нд Хэйлунзян мужийн салбар цэргийн тойргоос Жэньбаодао районд түрэмгийллийг няцаах байлдааны төлөвлөгөө боловсруулав. ХКН-ын Төв Хороо төлөвлөгөөг сайшааж Зөвлөлт Холбоот Улсын эсрэг хориглон хамгаалж, сөрөг давшилт хийх тулгуур цэгээ хэмээн Жэньбаодао районыг сонгон авав.

Хилийн байлдаанд оролцсон даргалах ба цэргийн бие бүрэлдэхүүнийг шагнах тухай зарлиг Цэргийн төв зөвлөл гаргаж, Сунь Юйго нарын 10 нөхдөд байлдааны баатар цол шагнав. Жэньбаодао хавьд болсон хилийн мөргөлдөөн бол Хятад-Зөвлөлтийн харилцаа чинээндээ тултал хурцадсаныг харууллаа. Зөвлөлтийн цэргийн аюулыг саармагжуулан зогсоох нь БНХАУ-ын дотоод, гадаад бодлогын чиг

шугамын хамгийн торгон үзүүр боллоо. 1969 оны 3 дугаар сараас улс орон даяар байлдааны бэлэн байдлыг дээшлүүлэх арга хэмжээг өргөн цар хүрээтэй авлаа.

Жэньбаодаод болсон тулалдааны тухай нөхөр Мао Зэдунд 1969.03.15-нд илтгэсний дараа тэрээр БНХАУ-ын зүүн хойд, умард, баруун хойд бүс нутгуудад бэлтгэл арга хэмжээ яаралтай авахыг үүрэг болгов.

- Маш том дайсантай тулгарлаа. Иймд дайчлах, дайнд бэлтгэх арга хэмжээ авах нь гарцаагүй боллоо. Гэхдээ бид өрсөж цохилт өгөхгүйгээр зайлшгүй хариу барих болно хэмээн Мао дарга айлдлаа.

1969 оны 6-7 дугаар саруудад Цэргийн төв зөвлөл хуралдаж дээрхи гурван бүс нутаг дахь оперативын цагийн байдлыг хэлэлцэж, зөвлөлтийн халдан түрэмгийллийг няцаах төлөвлөгөөг боловсруулав. 1969.08.13-нд зөвлөлтийн арми нисдэг тэрэг, танк, хуягт тээвэрлэгч хэрэглэн, хэдэн зуун цэргээр Хятадын Шинжаан-Уйгурын өөртөө засах орны Юйминь уезд дэх Жаланашколь нуурийн хавиар халдан түрэмгийлж, олон тооны хятадын хилчдийг алж шархдуулан маш ноцтой цуст мөргөлдөөн өдөөлөө. Үүний сацуу СССР нь Хятадад цөмийн цохилт яаралтай өгөх тухай мэдэгдлээ америкийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан тараалаа. Ийнхүү дайны уур амьсгалыг Зөвлөлт дэвэргэлээ.

Халдан орж ирсэн дайсныг ямар ч нөхцөлд, хэзээ ч устгахад бэлэн байхыг бүх орны нийт цэргийн албан хаагчид, иргэдэд уриалсан захирамжаа ХКН-ын Төв Хороо 1969.08.28-нд гаргалаа. Улс орон даяар агаарын довтолгооноос хамгаалах иргэний хамгаалалтын удирдах бүлгүүдийг байгуулж, бөмбөгнөөс хоргодох байр барих ажлыг эхлүүлэхээр Намын Төв Хороо шийдвэрлэв. 1969.09.17-ны өдрийн "Жэньминь жибао" сонинд БНХАУ байгуулагдсаны 20 жилийн ойн уриа нийтлэгдэв. Уг уриаг Мао Зэдун хүлээн аваад дараахи өгүүлбэрийг нэмж оруулав. Үүнд:

- Бүх дэлхийн ард түмнүүд империализм, социал-империализмын өдүүлсэн түрэмгий дайны эсрэг, ялангуяа цөмийн зэвсэг хэрэглэх

ОЛОН УЛС СУДЛАЛ

түрэмгий дайны эсрэг бүхий л хүчээрээ нэгдэн нягтрагтун! Хэрэв тийм дайн дэгдэж гэмээ нь бүх дэлхийн ард түмнүүд хувьсгалт дайнаар түрэмгийлэгчдийг устгах ёстой, үүний тулд өнөөдрөөс эхлэн бэлэн байдалд байгтун!

Хятад руу СССР-ээс халдан түрэмгийлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор 1969 оны 9 дүгээр сарын дундаас эхлэн Төв Хорооны удирдлагын төлөөлөгч, ахмад зүтгэлтэн нөхдийг Бээжин хотоос Бээжин-Гуанжоугийн төмөр замын дагуухи хотууд руу илгээхээр ХКН-ын Төв Хорооны Улс төрийн Товчоо шийдвэрлэв. Цэргийн төв зөвлөлийн канцелярыг Бээжин хотын баруун зах руу нүүлгэж, Жанжин штабт байлдааны бэлэн байдлыг гардан хариуцах командын бүлгийг байгуулав. Армийн бүх анги салбаруудыг байлдааны өндөржүүлсэн нэгдүгээр зэргийн бэлэн байдалд шилжүүлэв. Бүх улс орон даяараа дайны өмнөх байдалд шилжлээ. Бүх орон нутагт дайчилгаа явагдаж, бэлэн байдлын сургууль хийж эхлэв. Бүх шатны удирдах байгууллагуудыг дайны байдалд шилжүүлж, хотын хүн ам, нөөц баялгийг нүүлгэн шилжүүлэх, газар доорхи бөмбөгнөөс хоргодох байр барих, ардын өрхийн цэргийг зохион байгуулах, цэргийн зориулалттай зам гүүр барих, зэвсэг үйлдвэрлэх, дайны цагт хэрэглэх материал баялгийг нөөцлөх, ар талын хангалтын системийг буй болгох гэхчлэн их ажлуудыг өрнүүлэв. Өвөр Монгол, Хэйлунзян, Шинжаан, Гуандун зэрэг холбогдох цэргийн тойргийн харьяа бүс нутгуудад ХКН-ын Төв Хорооны тогтоолоор үйлдвэрлэл-барилгын цэрэгжсэн бригадуудыг 1968 оноос эхлэн байгуулж ажиллуулав...

1969 оны 6 дугаар сард Брежнев “Азийн хамтын аюулгүй байдлын систем” буй болгох санаачилгаа дэвшүүлсэн ба үүнийхээ дараа Зүүн өмнөд Ази, Япон зэрэг Хятадыг тойрсон бусад орнуудад 20 гаруй удаа зөвлөлтийн төлөөлөгчдийг илгээж, арга хэмжээ авч эхэлжээ. Төлөөлөгч илгээсний зорилго нь тэдгээр орнуудын цэргийг Хятадын хойд хил рүү татан төвлөрүүлж, Хятадыг бүслэн хаасан цагариг буй болгох явдал байв.

Ер нь 1964 оноос хойш хятад-зөвлөлтийн хил дээрхи байдал хурцадсан юм. Хятад-Зөвлөлтийн 7600 километр урттай хилийн дагуухи СССР-ийн цэргийн тоо байнга өсөн нэмэгдэж байлаа. 1960-

аад оны сүүлч, 1970-аад оны эх гэхэд хил дагуухи зөвлөлтийн дивизийн тоо 40 хүрч, тун удалгүй 50 дивиз болж нийт нэг сая цэрэг тэнд бэлэн байдалд байв. Гэтэл Хрущевын үед хил дээрхи дивизийн тоо 10 байсан билээ. Энэ хугацаанд Хятад–Монголын хил рүү СССР-ийн цэргийн хүчин түрэн орж ирсэн ба Монголд пуужингийн баазуудаа байгуулж, Бээжин хотоос хэдхэн зуун километрийн зайд цэргийн аюултай цайзаа байршуулаад байлаа.

1968 оны 8 дугаар сард зөвлөлтийн цэрэг Чехословак улсад цөмрөн орлоо. “Хязгаарлагдмал бүрэн эрх”, “Энх тайвны диктатур”, “Социалист гэр бүл”, “Нэгдмэл эрх ашиг”, “Том гүрний онцгой хариуцлага” гэгч номлол тэр үед буй болж хожмоо “Брежневизм” хэмээн нэрлэгдэв. Эл номлол нь социалист бусад орны дотоод хэрэгт хөндлөнгөөс балмадаар оролцохын зөвтгөл болж байлаа. Энэ бүхэн жанжлалын үнэн төрхийг нь илчилсний сацуу Зөвлөлт Холбоо Улс бол олон улсын норм, хэм хэмжээг хөсөрдүүлж, бусад орны бүрэн эрхийг бүдүүлгээр эвдэн сүйтгэдэг гэдгийг яруу тодоор илтгэн харууллаа. СССР бол Хятадын төрийн аюулгүй байдалд хамгийн ихээр бодитойгоор заналхийлэгч болохыг Хятадын ард түмэн одоо яг мэдэрлээ...

Хоёр. Зөвлөлтийн эх сурвалж ингэж өгүүллээ

Ю.М.Галенович.Россия и Китай в XX веке: Граница; А.Д.Богатуров, В.В.Аверков. История международных отношений 1945-2008, 2010; В. Ф.Вутурлинов, Г. К.Плотников, В. В. Чубаров. О Советско–Китайской границе: Правда и Пекинские вымыслы – зэрэг номын хэсгээс түүвэрлэн авав.

1969 оны 4 дүгээр сард хуралдсан ХКН-ын IX их хурал БНХАУ-ын гадаад бодлого дахь зөвлөлтийн эсрэг үзлийг улам нотлоод, хувьсгалыг үргэлжлүүлэн хийх, дайнд бэлтгэхэд чиглэсэн чиг шугамыг дэвшүүлэн тавьсан билээ. Дайнд бэлтгэх явдал “зөвлөлтийн эсрэг дайн” гэдгээр цаашаа өрнөв. Зөвлөлт Холбоот Улстай хиллэдэг хил дагуу цэрэг зэвсгээ хуралдуулж эхэллээ. 1967 он гэхэд СССР ба БНМАУ-тай хиллэдэг хилийн районуудад 264 мянган цэрэг бүхий 22 дивиз байрлаж байсан ба нутгийн гүнээс 400 мянган цэрэг дайчлан

авчрах тооцоо хийгээд байлаа. Манжуурт цэргийн маш хүчирхэг дэд бүтцийг байгуулжээ. Инженерийн саад, газар доорхи хоргодох байр, зам гүүр, аэродромуудыг тэнд бүтээн босгожээ. “Умрын аюул” гэдэг хятад ойлголт нь домгийн шинжтэй бус, харин ч бодитой оршиж буй, тун аюултай үзэгдэл болжээ.

Зөвлөлт-Хятадын харилцаа тун хүнд амаргүй байлаа. СССР ба БНХАУ-ын хооронд цэргийн мөргөлдөөн гарцаагүй хэмээн өрнөдөд цуурхаж, харин ч бүр хүсэн хүлээж байлаа. “Хувьсгалын эсэргүүтэй тэмцэх” зорилгоор 1968 онд Чехословакт зөвлөлт болоод Варшавын гэрээнд оролцогч бусад улсын цэрэг орсон явдал Зөвлөлт-Хятадын харилцаанд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн нь мэдээж. Энэ алхмыг Хятадад шал өөрөөр хүлээн авчээ. Чехословакт цэрэг оруулсантай адил үйл явдал БНХАУ-ын эсрэг үйлдэгдэнэ хэмээн хятадууд сандран мэгджээ. “Соёлын хувьсгал” гэгчийн жилүүдэд БНХАУ нь дотроосоо суларсан байсан тул тэгж айхаас ч аргагүй байсан биз. Харин энэ айдсыг өрнөдөд элдвээр өөгшүүлэн дэвэргэв. “Хоргодох байрыг гүн ухаж дайнд бэлтгэх” уриа Хятадад улам чанга сонсдох болов.

Уссури мөрний Даманы арал дээрхи хилийн зэвсэгт мөргөлдөөн Зөвлөлт-Хятадын 1960–1970-аад оны сөргөлдөөний оргил нь байлаа. Энэ бол хилийн санаандгүй мөргөлдөөн байгаагүй юм. Энэ бол энэ районд зөвлөлтийн хилийн цэргийн эсрэг өдөөх байлдааны ерөнхий сургуулилалт болсон юм. Анхны сургуулилалтаа хятадууд 1967, 1968 оныг дамнуулан өвлийн тэсгим хүйтнээр Уссури мөрний Киркинский (Цилициньдао) арал дээр хийжээ. Даманы арлын хувьд 1860 оны Бээжингийн гэрээ, 1861 оны хилийн зургийн дагуу Уссури мөрний усны хагалбараар бус, Хятадын эргээр хиллэнэ гэж заагдсан тул яалт ч үгүй Зөвлөлтийн нутаг юм. Зөвлөлт-Хятадын найрамдлын он жилүүдэд энэ арал дээр хятад иргэд чөлөөтэй нэвтрэн ирж, ногоо тарьж, өвс хадлангаа бэлтгэж байсан ба зөвлөлтийн хилчдийн зүгээс саад хийж байсангүй. Гэвч харилцаа хурцадмагц энэ практик зогсож, нөгөө эргийн байдал өөрчлөгдөж байгаа нь зөвлөлтийн хилчдийн нүдэн дээр илт болжээ. Хятадын талын эрэг дээр цэрэгжсэн суурингууд байгуулагдаж, зөвлөлтийн эсрэг хийрхэл ихсэж, ил далд тагнан турших болжээ. Тэр хавийн 200 километр урттай хилийн

бүсийг “батлан хамгаалах тэргүүн шугам” хэмээн Хятадад зарлалаа. Хариуд нь зөвлөлт хүлээнэсэнгүй, хилийн шугамдаа инженерийн тоноглол хийж эхэлжээ. Хилчдээ ч хүнд зэвсэг, пулеметээр зэвсэглэж, заставуудыг БТР-60 хуягт тээвэрлэгчээр хангав. Ойролцоох зэвсэгт хүчний ангиудтай хоршин ажиллахаар хилийн цэргээ дахин бүлэглэв.

1968 оны сүүлчээс Хятадын зүгээс өдөөн хатгалга зохион байгуулалттай, өргөн хүрээтэй явагдаж, бүр тогтмолжив. 1969.01.25-нд Шэньяны цэргийн тойргийн штабт СССР-ийн хил дээр цэргийн ажиллагаа явуулах төлөвлөгөө боловсруулж дуусгав. Шэньяны цэргийн тойргийн командлагчийн орлогч Сяо Цюяньфу цэргийн ажиллагааг удирдах ба салбар тойргийн штабын дарга Ван Зылян командын пунктээ байгуулан ажиглалт хийж байлаа. 1969.02.19-нд ХАЧА-ийн Жанжин штаб тусгай ажиллагааны төлөвлөгөөг баталлаа. Тэр ажиллагааг “Хариу үйлдэл” хэмээн кодлон нэрлэ гэж ХКН-ын Төв Хорооноос зарлигджээ.

“Хариу үйлдэл”-ээрээ юуны өмнө зөвлөлтийн талын түрэмгий санаархлыг илчлэхийг зорино гэнэ. Тэгэхийн тулд зөвлөлтийн шинэ төрлийн зэр зэвсэг, галт хэрэгсэл, бичиг баримтыг олзлон авах болно. Гэрэл зургийн архив буй болгож СССР-ийн түрэмгийллийг гэрэл зургаар баримтжуулна. Гэнэт халдаж түргэн шуурхай ажиллаж Даманы арал дээр сүр хүчийг үзүүлнэ. Үүргээ биелүүлээд үтэр түргэн холдож бэхлэсэн газраа хүрнэ гэхчлэн тэр төлөвлөгөөнд тусгасан байж. Гэтэл ХАЧА-ийн Жанжин штаб “Хариу үйлдэл”-ийг өөрчлөв. Зөвлөлтийн талыг шийдэмгий ажиллагаа хийхэд хүргэж болохгүй гэж үзэв. Зөвлөлтийнхөн зэвсэг хэрэглэвэл л хариу хэрэглэ, гэхдээ “өөрийгөө хамгаалах зорилгоор” давуулж хэрэглэ, зөвлөлтийн хилчид давшаад Хятадын нутагт ороод ирвэл амьдаар нь баривчил гэж зааж өгчээ. Хятадын тал Даманы арлын төлөөх байлдаанд эртнээс бэлтгэж, ойролцоох толгод дээр командын байр байгуулчихсан тэндээс ХАЧА-ийн дарга нар байлдааныг ихэд сурмаг ухаалаг удирдаж байсныг зөвлөлтийн хилийн отрядын дарга А.Д.Константинов дурсамждаа бичиж үлдээсэн нь бий.

Ингээд 1969.03.02-ны Ням гаригийг хятадууд сонгон авчээ. Амралтын өдөр. Москвад бүх албан байгууллага хаалттай, босоо

ОЛОН УЛС СУДЛАЛ

тогтолцоотой Зөвлөлтөд зохицуулалт хийх боломжгүй. Бас “Масленица” хэмээх өвлийг үдэх орос ардын баярын өдөр, бүгд налайж найрлаж суугаа. Зөвлөлтийн хилийн отрядын дарга нар баяр хэсээд алга болсон, амралтын өдөр хилийн авиац нь нислэг хийдэггүйг давхар тооцсон хятадын 300 цэрэг 2-ны үүр шөнөөр мөсөн дээгүүр арал руу дөхлөө...

Эхний тулалдаануудад зөвлөлтийн хилчид гарз хохирол амслаа. Хилийн 69-р отряд байлдаанд оролцож БТР-60, пулемет, гранатомет хэрэглэн хятадын цэргүүдийг тогтоон барьсаар байв. 12-ны шөнөөс Алс Дорнодын цэргийн тойргийн мото-буудлагын 135-р дивизийн ангиуд хилийн тулалдаанд оролцлоо. Даманы арлын үйл явдал хилийн мөргөлдөөнөөс хэтэрч, хоёр социалист улс хоорондын зэвсэгт мөргөлдөөн болж цааш даамжирлаа. 14-нд хятадууд дахин Даман руу атакллаа. 15-наас Хятадын талаас их буу, минометоор галлан дахин давшлаа. Солонгосын дайнд хэрэглэж байсан “хүн давалгаа” тактикаа тэд хэрэглэж үзлээ. Зөвлөлтийн Т-62 танкийг хятадууд олзлон авлаа. Дотор нь хилийн отрядын дарга хурандаа Д.В.Леонов амь эрсэдлээ. Зөвлөлтийнхөн энэ шинэ танкаа хятадаас ихээхэн нууцлаж байсан нь талаар болж, хожмоо тэр танк Бээжин дэх ХАЧА-ийн музейн үзмэр болж билээ.

1969 оны тэр өдрүүдийн байлдаанаар юу ажиглагдав. Зөвлөлтийн тал улс төрийн хувьд ийм дайнд огтоос бэлэн бус, Москва дахь дээд командлал ус балгасан мэт таг чиг, Алс Дорнодын цэргийн тойрог руу ямар ч удирдамж тушаал очсонгүй. Мото-буудлагын 135-р дивизийн их бууны ангиудыг тулалдаанд оруулснаар зөвлөлтийн цэргүүд хятадын “хүн давалгаа”-ны аюулаас аврагдлаа. Усуури мөрний нөгөө эрэг рүү, 5-6 км гүн рүү БМ-21 “Трад” хэмээх орчин үеийн тийрэлтэт сумаар галласны дараа хятадууд амь зулбан зугтлаа. Шинэ төрлийн катюшийн шуурган галаар хятадуудыг үлдэн хөөлөө. 1969.03.02-16-нд Даманы арлын орчим болсон хилийн байлдаанд зөвлөлтийн 58 хилчин алагдаж, 94 цэрэг шархдав. Хятадын тал 600 цэргээ алуулав. Хилийн байлдаан дууссан ч дараа нь Даманы арлын орчим зэвсэг хэрэглэсэн гал, нээсэн 300 гаруй хилийн зөрчил гарсан ба Амар мөрний зарим арал дээр ч ийм будлиан гарсаар байв. 1969 оны зунаас Зөвлөлт

Казахстаны Жаланашколь нуурын районд Зөвлөлт–Хятадын хилийн мөргөлдөөн үргэлжиллээ. 1969.08.12-13-нд зөвлөлтийн хилийн заставууд тулалдаанд орлоо. Харин энэ удаа Москвагаас тун толорхой оновчтой үүрэг чиглэл өгчээ. Дорнод хилийн тойргийн командлагч генерал Меркуловын дурссанаар бол, “Аль болох ахиухан тооны зэр зэвсэг олзлон ав, алагдсан хил зөрчигчдийн шарилыг авч хадгал, болж өгвөл амь хэн олзол” гэхчлэн Москвагаас заварлаж байжээ...

1969.09.11. Зөвлөлт засгийн газрын тэргүүн А.Н.Косыгин Ханойд Вьетнамын Ерөнхийлөгч Хо Ши Минийг хөдөөлүүлэх ёслолд оролцоод буцахдаа Бээжинд газардлаа. Бээжингийн аэропорт дээр түүнийг БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Жоу Энълай угтан авч “Зөвлөлт–Хятадын харилцааны зарим асуудал, түүний дотор хил дээрхи байдал”-ыг хэлэлцлээ. Энэ бэсрэг уулзалтын талаархи мэдээлэл төдийлөн элбэг биш. Гэвч улс төрийн ач холбогдол нэн их ээ. СССР, БНХАУ хоёр, хоёр том коммунист гүрэн цэрэг–дайны мөргөлдөөний ирмэгт ирсэн үед тэгж уулзсан хэрэг шүү дээ. Хоёр том коммунист гүрэн өвөр хоорондоо дайтаад уналаа хэмээн өрнөдөд ид шуугиж эхэлж байх үед тэгж уулзаад өрнөдийнхний амыг таглаж чадсан хэрэг л дээ. Косыгин, Жоу Энълай хэмээх хоёр аугаа их зүтгэлтний гавьяа гэж үнэлж баршгүй. Тэр хоёр гурван цаг хагас уулзаад консенсуст хүрсэн ба дахиж хилийн асуудлаас болж Зөвлөлт, Хятадын хэн хэн нь дайн эхлүүлэхгүй хэмээн тэр консенсусээр үүрэг хүлээжээ. “Хувьсгалыг үргэлжлүүл, дайнд бэлтгэ!” хэмээх маоист уриа Косыгин, Жоу Энълай нарын уулзалтаар гэдрэг шидэгдлээ.

Гурав. Москвагаас атомын бөмбөг горьдоод амаа таглуулснаас бүх зөрчил эхтэй¹

1950-иад онд Хятадын бүтээн байгуулалтад СССР ид тусалж, мэргэжилтнээ илгээж, хятад мэргэжилтнүүдийг СССР-т бэлтгэж байсан ба атомын бөмбөгтэй болоход минь туслаач гэсэн Мао даргын гуйлт тэр үед Москва руу очсон билээ. Анхлан 1953 оны хавар эхний

¹Хятад, Зөвлөлтийн (Орос) эх сурвалжаас буулгаснаа баяжуулан тухайн үеийн хоёр их хөршийн маань зөрчлийн уг сурвалжийг хайхыг судлаачийн хувьд хичээв. Тэр тухай эдүгээ өгүүлэхэд алдах зүйл байхгүй. Тэгэх тусмаа Элчин сайдын байр суурь хэмээн хүлээн авахгүй байхыг хүснэ.

ОЛОН УЛС СУДЛАЛ

удаа Зөвлөлт Холбоот Улсад ханджээ. Хятадын шинжлэх ухаан, аж үйлдвэрийн потенциал сул байгаа тул атомын зэвсэгтэй болно гэх үзлээсээ татгалзахыг тэр үед Н.С.Хрущев тэдэнд уриалаад харин иргэний зориулалттай атомын байгууламжтай болоход чинь бид тусламз гээд амлчихаж.

1954 онд Зөвлөлтийн Өмнөд Уралын цэргийн тойргийн Тоцкийн полигонд атомын бөмбөг хэрэглэсэн дайнд хэрхэн ажиллах вэ гэдгийг харуулсан ерөнхий цэргийн хээрийн сургууль болжээ. Атомын бөмбөг хаяад дайсныхаа хориглолтыг сэтэлж байгаа ажиллагааг боловсруулах нь хээрийн сургуулийн зорилго байсан ба сургуулийг маршал Георгий Жуков өөрөө биечлэн удирджээ. Атомын бөмбөгтэй хээрийн сургуульд 45 мянган цэрэг, 600 танк, өөрөө явагч их буу, 500 их буу, катюш, 6000 автотрактор, Ил-28, МиГ-15 и МиГ-17 маркийн 320 нисэх онгоц оролцжээ. Хүндэт зочдын дотор БНХАУ-ын Батлан хамгаалахын сайд Пэн Дэхуй, БНХАУ-ын орлогч дарга Жү Дэ болон ХАЧА-ийн олон дарга нар бахархсан, сүрдсэн байдалтай алмайран зогсож байлаа.

Тоцкийн полигоны атомын бөмбөгний энэ сургууль Хятадын удирдагчдын цэрэг-дайны хийрхлийг чухам дэвэргэж өгсөн гэж түүхчид үздэг. Тоцкийн полигонд үзэж харсан тэр их зэвсэг техник Хятадад байгаасай гэх харуусал, шунал тэр үед буй болж тэр нь цаашаа даамжирлаа. Тариачны армиар хол явахгүй юм байна гэдгийг маршал Пэн Дэхуй, Жү Дэ нар яс махандаа тулгал ойлгожээ.

1955.01.15-нд ХКН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга нарын газраас өөрийн цөмийн зэвсгээ боловсруулж бүтээх тухай шийдвэр гаргалаа. Залгаад 20-нд хамтарсан геологийн хайгуул Шинжаанд хийх тухай зөвлөлт-хятадын хэлэлцээр байгуулагдлаа. Энэ хэлэлцээрээр бол геологийн хайгуул хамтран хийгээд шанд нь хятадын ураны илүүдлийг зөвлөлт авч байхаар болжээ. Энэ төсөлд дорнод европын социалист орнуудын мэргэжилтнүүд ч оролцжээ. Шинжааны Чугучак хотын орчмоос уран олборлодог үйлдвэр 1957 оноос ажиллаж эхлэв.

Мао даргын гуйлтад Москва нааштай хандсаны илрэл нь Шинжаан дахь ураны энэ орд болсон ба 1956.04.07-нд иргэний ба цэргийн шинэ объект барьж байгуулахад нь СССР-ээс БНХАУ-д

туслах тухай шинэ хэлэлцээр байгуулагдаж, тэр жагсаалт дотор "атомын бөмбөг үйлдвэрлэх завод" гэсэн нэрс цохиж явах нь тэр. Мөн оны өвөл ХКН-ын Төв Хороо "Атомын эрчим хүчийг хөгжүүлэх тухай" тогтоолоо батлав. ХАЧА-ийн шинэ үүрэгт нь стратегийн пуужин, атомын бөмбөг бүтээх заалт нэмэгдэж, "Машин угсралтын 3 дугаар яам" нэрээр атомын бөмбөг бүтээх төрийн төв байгууллага ажиллаж эхэллээ. Атомын зэвсэг бүтээх улс төрийн удирдагчаар Сталин До яамны махчин Берияг томилж байсны адил Мао дарга "хятад Берия" болох Кан Шэнийг томилов. Сталины нэг адил олон мянган улс төрийн хоригдлыг Хятадад мөн энэ ажилд боол болгон ашиглажээ.

1956 онд Унгар, Польшид Зөвлөлтийг эсэргүүцсэн ардын бослого дэгдэж, Москвагийн нэр төрд хир суусан ба улс төрийн дэмжлэг олох зорилгоор Хятадтай харилцаагаа улам тэлж өргөжүүлээ. Бээжин ч хариуд нь атомын зэвсэг бүтээхэд хэрэгтэй тэр технологио Москвагаас салгаж эхлэв. 1957.10.15-нд Зөвлөлт-Хятадын шинэ хэлэлцээрээр (нууц) БНХАУ-д атомын бөмбөгний технологи төдийгүй түүний загварыг шилжүүлэхээр заажээ. 1958 оны эхнээс зөвлөлтийн мэргэжилтэн-атомщик инженерүүд Хятад руу цувж эхэллээ. Ер нь 10 мянга орчим атомщик мэргэжилтэн Хятадад очсон байдаг ба зөвлөлтийн цөмийн цэнэгийн гол зохион бүтээгч Е.А.Негинийг "Арзамас-16" хэмээх хаалттай хотоос, Е.Воробьевыг "Челябинск-40" хэмээх хаалттай хотоос Хятад руу илгээсэн байдаг. Лобнуур дахь цөмийн полигон зөвлөлтийн атомщик инженерүүдийн хүчээр бослоо. Хүнд усны цөмийн реакторыг тэд 1958 оны намар Хятадад байгуулж, Хятадын ШУА-ийн мэдэлд шилжүүллээ. Хятадын мянга мянган мэргэжилтэн, эрдэмтэд СССР-т мэргэжил эзэмшлээ.

Гэтэл Зөвлөлт, Хятадын хооронд үзэл суртлын маргаан дэгдэж, 1957 оны Зөвлөлт-Хятадын нөгөө нууц хэлэлцээрээ Москва үл биелүүлж эхэлсэн ба "гаднын тусламжгүйгээр 8 жилийн дараа гэхэд хүссэн бөмбөгөө бид бүтээх болно" хэмээн хариуд нь Жоу Энлай мэдэгдэв. БНХАУ-ыг атомын зэвсэгтэй болгоно гэх амлалтаасаа СССР 1959 оны 6 дугаар сар гэхэд татгалзав. Загвар бөмбөг, хэрэгцээт нэмэлт техник тоног төхөөрөмжөө өгөхгүй гэв. БНХАУ байгуулагдсаны 10 жилийн ойн баярт уригдаж очсон Н.С.Хрущевос 1957 оны нууц

ОЛОН УЛС СУДЛАЛ

хэлэлцээрээ сэргээн дагаж мөрдөхийг Мао гуйсан боловч нааштай хариу сонссонгүй. “Ерөөсөө атомын зэвсэг хийхээ больчих, бид Та нарыг, нийт социалист лагерийг Зөвлөлт Холбоот Улсын цөмийн зэвсэг найдвартай хамгаална” гэж Хрущев батлан хэлэв. Хариуд нь Мао Жоу Энълайн нөгөө шазруун мэдэгдлийг давтав. Мао Зөвлөлтийн техникийн хүчинд найдахаа больж, Хятадын хүний асар их хүчинд найдлаа.

Энэ завсар Хрущев, Мао нарын оролцоотой хачин сэдлүүд нэг бус гарч байлаа. Зах зухаас нь дурдвал, Варшавын гэрээний байгууллага, НАТО-г нэгэн зэрэг татан буулгах тухай Хрущевын энх тайванч санаачилгыг Мао Зэдун учиргүй эсэргүүцэв. Түүнийхээр бол энэ хоёр цэргийн эвсэл байлдаад НАТО нь ялаад Варшавын гэрээний байгууллага нь ялагдаад Зөвлөлт эзлэгдсэн ч Уралын нуруу хүртэл ухраад эргээд давших ёстой юм байна. Мөн нэг сая хятад ажилчныг Сибирьт байршуулах тухай Хрущевын саналыг Мао учиргүй хилэгнэн хүлээн авав. Тэгснээ Мао 180 градус эргэв. СССР-ийн эзэнт гүрний санаархал, хятадуудын хувьд боолчлол, доромжлол гэж үзэж байснаа гэв гэнэт зөвшөөрөөд нэг сая хятадаа Сибирь рүү явуулахаар Москваг ятгав. Тэр үед нь Зөвлөлт цаашаа харчихсан, харин ч “Сибирийг дайнгүйгээр Хятадад эзлүүлэх нь” хэмээн хардаж цэрэг-зэвсгийн бэлтгэлээ базаасан байлаа.

Мөн 1960 он гэхэд ах дүү хоёр коммунист нам – ЗХУКН, ХКН-ын хооронд цусгүй дайн дэгдээд байлаа. “Ленинизм мандтугай!” гэсэн гарчгаар Зөвлөлт, ЗХУКН-ыг дайрч давшилсан өгүүлэл Бээжинд нийтлэгдсэнийх нь төлөө (сонины нийтлэл шүү дээ!) Зөвлөлтийн тал Хятадад хэлж мэдэгдэлгүйгээр бүх мэргэжилтэн, зөвлөгч сургагч нараа гэв гэнэт гэдрэг татаж Хятадыг гомдоов. Гомдол цааш даамжирч Хятад дахин зөвлөлтөөс мэргэжилтэн, зөвлөгч сургагч авахгүй гэв. Мэргэжилтнээ буцаан илгээе хэмээн Москва дахин дахин гуйгаад тусыг эс олов гэхчлэн жагсаагаад байвал бас ч үгүй чамгүй баримт буй аж.

Хятадуудыг ийнхүү эгнэгт гомдоосныхоо шанд Зөвлөлт-Хятадын харилцааг эрс хүйтрүүлж, тэр нь яван явсаар “1969 он”-той золгосон нь тэр билээ.